

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-4
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/	3-4

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 26-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 13 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Болормаа, Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Заяабал, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Да.Цогтбаатар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан, Нэр дэвших тухай хүсэлтийг “2024 оны 12 сарын 26-наас 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 10:00 цаг хүртэл” гэснийг “2024 оны 12 сарын 26-наас 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийг бүртгэх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн үг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 15 цаг 13 минут.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Даваасүрэн: Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг эрье.

Байнгын хорооны гишүүдийн хуралдаанд оролцож байгаа ирцийг та бүхэнд танилцуулъя.

Тилеуханы Аубакир гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Загджавын Мэндсайхан гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Дамбын Батлут гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Рэнцэндоржийн Батболд гишүүн, Батмөнхийн Батцэцэг гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн нар бүртгүүлсэн байна.

Хуралдааны ирц 52 хувьтай байгаа учраас Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар нэгхэн асуудал хэлэлцэнэ.

Өчигдрийн бид нарын Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн сонгох тухай асуудал маань олонхын санал авсан гишүүн гараагүй. Тийм учраас дахин зарлахаас өөр аргагүй нөхцөл байдал үүссэн учраас өнөөдөр дахин зарлахаар Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлэхээр та бүхэнд тараасан байгаа.

Ингээд хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? 1 санал байх ёстой, Батлут гишүүн ээ, тогтоолын төсөлтэй холбогдуулаад.

Батболд гишүүний микрофоныг өгье.

Р.Батболд: Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх олонхын санал авч чадаагүй. Тэгэхээр нэр дэвших тухай хүсэлтийг 2024 оны 12 сарын 26-наас 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 10 цаг хүртэл гэгчхсэн байгаа юм. Тэгэхээр энэ хугацааг 12 дугаар сарын 30-ны өдрийн 17 цаг болгож өөрчлөх санал гаргаж байна.

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ, ингэе. 1 дэх өдөр арай ч 10 цаг гэдэг бол бас нэр дэвшигч нарт боломж олгохгүй байна гэсэн учраас 1 дэх өдрийн ажлын цагийг бүтэн яая гэж байгаа юм байна, 17 цаг.

Тэгэхээр би Батболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалгачихъя.

Хугацааг 24 оны 12 сарын 30-ны өдрийн 17 цаг гэж өөрчилъе гэж байна. Санал хураалт явуулъя.

Батболд гишүүний саналыг 13 гишүүн оролцсоноос 11 гишүүн дэмжиж, 84,6 хувиар дэмжсэн байна. Цаг нь тэгвэл 17 цаг болж өөрчлөгдлөө.

“Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 15 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, 80 хувиар тогтоол батлагдлаа.

15.16 цаг

Би та бүхэнд бас нэг зүйлийг мэдээлэх ёстой. “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг холбогдуулаад ингээд зар явна.

Мөн Улсын Их Хурлын манай Байнгын хорооны гишүүн нэр дэвшигч санал болгох эрхтэй шүү. Та бүхэн. Нэр дэвшигч дэвшүүлэх санал болгох эрхтэй. Одоо энэ саяын нөгөө 1 дэх өдрийн 17 цаг хүртэл зар хойшлуулчихлаа шүү дээ, тийм ээ. Нэр дэвшигч өөрөө ирж бүртгүүлж болно. Мөн манай Байнгын хорооны гишүүдээс нэр дэвшигчийг бүртгүүлж болно.

Хэрэв бүртгүүлэхээр бол та бүхэн нэр дэвшиж байгаа хүнийхээ анкетыг Байнгын хорооны 213 тоот өрөөнд авчирч өгөөрэй.

Ингээд Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа.

Баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ